

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

НДШ-ийн зардлын тухай3

Асуудал 2

Нотлох баримтын бүрдүүлэлтийн талаар4

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, нягтлан бодогч нарт талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

Цалингийн зардлаас төлөх 118.6 мянган төгрөгийн шимтгэлийг НДШ-ийн зардлаас төлж, зардлын зүйл ангийг зөрүүлэн бүртгэж тайлагнасан байна. Энэ нь толилуулга, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

АГ-ын зөвлөмж

1. Хувь хүнээс суутгасан шимтгэлийг НДШ-ийн зардлаас төлсөн зөрчлийг давтан гаргахгүй байх.
2. НДШ-ийн зардлыг зориулалтын дагуу зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг асуудлын бүртгэл маягтаар төсвийн захирагчид танилцуулахад зөрчлийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж ирүүлсэн болно.

АГ-ын ажиглалт

Ажиллагсдын ажлын үр дүнгийн үнэлгээг үндэслэн төрийн алба хаасан хугацааны болон үр чадварын нэмэгдлийг олгох МХГ-ын даргын тушаал 2017 оны 1 сард гарсан боловч ажиллагсдын үр дүнгийн үнэлгээг баталгаажуулсан нотлох баримт байхгүй байна. Энэ нь тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

АГ-ын зөвлөмж

1. Ажиллагсдын ажлын үр дүнг үнэлсэн тухай болон ажлын үнэлгээний талаар нотлох баримтыг бүрдүүлэх

2. Нотлох болон анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг асуудлын бүртгэл маягтаар төсвийн захирагчид танилцуулахад зөрчлийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж ирүүлсэн болно.


МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР


АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ОЮУНТУЯА

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



Б.НАРАНЦЭЦЭГ

Огноо: 2018.02.20